



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Төмөр замын дээд сургууль

Хөтөлбөрийн нэр: Авто инженер

Индекс: D071601

Шинжээчийн баг:

Ахлагч: Ө.Ганбат

Гишүүд: Б.Оюунцэцэг  
Э.Нацагдорж

2019.05.27

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## **Товчилсон үгийн тайлбар**

- УБТЗ ХНН- Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэг
- ТЗДС- Төмөр замын дээд сургууль
- ИТА- Инженер техникийн алба
- ТЗММА- Төмөр замын машин механизмын ашиглалт

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Төмөр Замын дээд сургууль Railway Institute of Mongolia	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b>	Авто инженер	
<b>Индекс</b>	D071601	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч: Ө.Ганбат, Багийн ахлагч, ХААИС-ийн Инженер, Технологийн сургуулийн Механик инженерийн тэнхимийн эрхлэгч</p> <p>Гишүүд: Б.Оюунцэцэг, МУБИС-ийн Багшийн сургуулийн Сурган, сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч</p> <p>Э.Нацагдорж, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн Инженер механикийн тэнхимийн эрхлэгч</p>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Г.Даваажаргал, БМИҮЗ-ийн ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2019.05.03-05.07	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээг уншиж судлах, шинжээчийн урьдчилсан үнэлгээ хийх
	2019.05.09	Сургууль дээр ажиллаж нотлох баримтуудыг үзэж шалгах, сургуультай танилцах, ажил олгогч, багш нартай уулзах
	2019.05.10	Сургууль дээр ажиллаж нотлох баримтуудыг үзэж шалгах, тодруулга лавлагаа авах, оюутнууд, төгсөгчидтэй уулзах, шинжээчдийн дүгнэлт гаргах, байгууллагад танилцуулах
	2019.05.11-05.17	Шинжээчийн тайлан бичих
	2019.06.12	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үр дүнг Мэргэжлийн зөвлөлд танилцуулах
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрэм, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

---

Зам барилгын тэнхим 1994-1995 оны хичээлийн жилд шинэчлэн байгуулагдсан. Тус тэнхим Төмөр замын барилга, зам, замын аж ахуй болон Төмөр замын машин механизмын ашиглалт мэргэжлээр бакалавр зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 тоот тушаалыг үндэслэн ТЗДС-ийн захирлын 2018 оны А/244 тоот тушаалаар “АВТО ИНЖЕНЕР” хөтөлбөрөөр суралцаж Төмөр замын машин механизмын ашиглалт (ТЗММА) мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалт явуулах болсон.

Төмөр замын машин механизмын ашиглалтын мэргэжлээр сурч байгаа мэргэжилтэн нь техникчийн болон бакалаврын гэсэн хоёр шатны сургалт явуулдаг.

Бакалаврын сургалтаар бэлтгэгдсэн төмөр замын машин механизмын ашиглалтын мэргэжилтэн нь замын анги, зам засварын машин станцын машин механизмын оператор, механик, мастер, замын хүнд машин механизмын машинч, сэв шалгагч тэргэнцэр болон зам хэмжигч сэв шалгах вагоны техникч зэрэг ажлын байран дээр ажиллах боломжтой.

Тус мэргэжлийн бакалаврын шатны сургалтаар бэлтгэгдсэн мэргэжилтэн нь замын ангийн засварын газрын орлогч дарга, инженер, зам шалгагч ба сэв хайгч машины механик инженер, замын машин механизмын ашиглалтын ахлах мастер, машины дарга, ахлах, механик, засварын газрын дарга, замын аж ахуйн инженер, механикчийн бүх шатны ажлын байранд ажиллаж байгаа бөгөөд нийт 194 төгсөгчийг бэлтгээд байна.

---

## II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шинэчлэл хөгжлийн хөтөлбөрийн зэрэг бодлогын бичиг баримтад төмөр замын бодлогын талаарх **заалтууд**.
- Мэргэжлийн хөтөлбөрийг ОХУ-ын Эрхүүгийн Зам харилцааны их сургуулийн “Барилга, зам, өргөн тээвэрлэх машин төхөөрөмж” мэргэжлийн хөтөлбөр, ШУТИС-ийн хөтөлбөрүүдтэй харьцуулан 3 үндсэн бүлэг, 13 үзүүлэлтээр үндэсний болон олон улсын хөтөлбөртэй **харьцуулсан судалгаа**.

#### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

#### Онцлог зүйл/Туршлага:

- Монгол Улсаас төмөр замын талаар баримталж байгаа бодлогын бичиг баримтад тулгуурлан сургалтын хөтөлбөрийн үр дүн буюу мэргэжлийн загварыг гарган авсан байна.
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийж өөрийн хөтөлбөрийн давуу болон дутагдалтай талыг тодорхойлсон байна.

#### Анхаарах асуудал:

- Сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан нэгдсэн бодлогын бичиг баримт байхгүй байна.

#### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оролцогч талын оролцоо, үүрэг, хариуцлага шийдвэр хэрхэн гаргадаг талаар нэгдсэн хөтөлбөрийн хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, эсвэл хөтөлбөрийн бодлогын бичиг баримттай болох.

#### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөлийг шинээр байгуулан хөтөлбөрийн зорилго, зорилтын хэлэлцэхээр **баталсан төлөвлөгөө**.
- ТЗДС-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, уриаг сурталчилсан **зурагт танилцуулга**.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг сургуулийн вэб хуудсаар олон нийтэд зарласан **линк**. Сургуулийн вэб хуудсанд бичсэн хөтөлбөрийн зорилго, зорилт нь өөрийн үнэлгээний тайлангийн бичлэгтэй нийцэж байв.

#### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтын талаар ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авсан нь сайн туршлага болсон байна.

**Анхаарах асуудал:**

Байхгүй.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо оюутан сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвартаа тулгуурлан 5-6 жилийн дараа хэрхэн хөгжиж ямар түвшин хүрсэн байхыг тодорхойлох.
- Тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд ажил олгогчдын зөвлөлийг байгуулан дүрэм журмыг шинэчлэн боловсруулах.

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадвар, хандлагад нийцүүлэн бакалаврын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг хангаж, шинэчлэн боловсруулсан **сургалтын төлөвлөгөө, Авто Инженерийн мэргэжлийн хөтөлбөр.**
- Хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг хянах, бичиг баримт боловсруулахад ТЗДС-ийн “Хөтөлбөрийн чанарын үнэлгээний журам”-ын дагуу оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, дүгнэлтийг үндэслэн **ажлын төлөвлөгөө.**
- Ажил олгогч талыг төлөөлж УБТЗ-ын зам, замын аж ахуйн албаны ИТА-тай хамтран хөтөлбөрийн үр дүнг нарийвчлан тогтоосон **хурлын тэмдэглэл.**

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Ажил олгогч талыг УБТЗ-ын зам, замын аж ахуйн албаны ИТА гүйцэтгэдэг тул сургалтын үйл ажиллагааны талаар нягт хамтран ажилладаг.

**Анхаарах асуудал:**

Байхгүй.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн үр дүнг төлөвлөгөө гарган үнэлэх аргачлал шинээр боловсруулах

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Төмөр замын мэргэжлийн сургалтын журам, оюутны журам, код батлах тухай тушаал байна.
- Хөтөлбөрийн шинэчлэл нь суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн “Үр дүнд суурилсан сургалтын арга зүй”-CDIO –г тасралтгүй хөгжүүлэх чиглэлтэй, Төмөр

замын барилга, зам, замын аж ахуй болон Төмөр замын машин механизмын ашиглалт мэргэжлээр бакалавр зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛӨӨР баталгаажуулан хэрэгжүүлдэг.

- Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 тоот тушаалыг үндэслэн ТЗДС-ийн захирлын 2018 оны А/244 тоот тушаалаар “АВТО ИНЖЕНЕР” хөтөлбөрөөр суралцаж, Төмөр замын машин механизмын ашиглалт (ТЗММА) мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалт явуулах онол арга зүйн зохистой харьцаатай, тасралтгүй хөгжих, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй болно.
- Хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөлийг шинээр байгуулан, суралцагчийн эзэмших цогц чадамжийг төлөвшүүлэх техникчийн болон бакалаврын гэсэн диплом олгодог байна.

## **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

### **Онцлог зүйл/Туршлага**

- Сургалтын агуулгын давхцалыг нарийвчлан гаргаж, оюутан суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурлан, онол, дадлага хосолсон хамтран суралцах, идэвхтэй сургалтын арга зүйг хөгжүүлж буй, гар сэтгэл нийлсэн профессорын баг ажиллаж байгаа нь сайшаалтай байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг өөрчлөн, шинэчилсэн бөгөөд дээд боловсролын чанарыг эрхэмлэн, авто инженер бэлтгэн гаргахад чиглэгдсэн хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсронгуй болгосон.
- Лабораторийн ажил, мэргэжлийн дадлагыг өөрсдийн бааз төмөр замын ангиудад туршлагатай инженер багш, мэргэжилтнүүд зөвлөн тусалж чиглүүлж байгаа нь тэдний хамтын ажиллагааг ойртуулан бэхжүүлж, ажлын байранд түшиглэсэн шинэчлэлийг хийхэд чухал ач холбогдолтой болсон байна.
- Авто инженер хөтөлбөрийг өөрчлөн шинэчлэхдээ хөтөлбөрийн баг томилон шинжилгээ хийлгэж, мэргэжлийн хичээлүүдийн агуулгыг аль болохуйц давхардалгүй байлгах, хичээлүүдийн агуулгын хоорондын уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажилласан байна.
- Нээлттэй үзүүлэх хичээлийг багш нар графикийн дагуу тогтмол явуулж, сайн туршлагаас хамтран суралцах, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж өгсөн.
- Суралцагчдын эрэлт хэрэгцээ, хөгжлийн асуудлыг харгалзах үүднээс дээд боловсролын стандартын загварт өөрчлөлт оруулах тухай БСШУС-ын сайдын А/174 дүгээр тушаалын дагуу сургалтын төлөвлөгөөний 25:30:45 харьцааны тохирц хангалттай гэж үзлээ.

### **Анхаарах асуудал:**

- Байхгүй.

### **Зөвлөмж:**

- Сургалт, үйлдвэрлэлийн дадлагын цагийн багтаамжийг нэмэгдүүлэх.

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багш бүр суралцагч төвтэй “Үр дүнд суурилсан арга зүй”-г түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. /Сургалтын албаар баталгаажуулсан/
- Мэргэжлийн онцлогт нийцүүлэн, суралцагчдын онолын мэдлэгийг хэрэглээ болгох чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах, заавар, удирдамжууд нь мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан журам заавруудтай.

## **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**



### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын заах ур чадварыг дээшлүүлэх, сургалтын чанарт ахиц дэвшил гаргах зорилгоор “Үр дүнд суурилсан сургалтын арга зүй”-CDIO сургалтыг 4 удаа зохион байгуулж, хөтөлбөрт хичээл заадаг бүх багшийг хамруулсан сайн талтай.
- 2017-2018 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлыг хангах зорилгоор “Багш нарын сургалтын бичиг баримтыг сайжруулах сар”-ын ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үнэлгээ өгч ажилласан байна.
- Хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд багш нарын сургалтын бичиг баримтын иж бүрдлийг хянаж, зөвлөгөө өгч, тэмдэглэл хөтөлж, тухай бүрд сайжруулалт хийж ажилладаг.
- ТЗДС нь CDIO үр дүнд суурилсан сургалтын арга зүйг сургалтад нэвтрүүлснээр багш нарын CDIO стандарт, арга зүйн талын мэдлэгийг дээшлүүлэх боломжтойг харуулав.
- Хөтөлбөрийн зорилготой уялдаж, ажил олгогчидтой /мэргэжлийн алба/ хамтарсан хөтөлбөрийн хэлэлцүүлгийг хөтөлбөр бүрээр зохион байгуулсан.
- Багш нарын заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хийж эхлээд байна.
- ТЗДС-ийн хөтөлбөрийн чанарын үнэлгээний журамд зааснаар хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүрийн төгсгөлд үнэлэхээр заасан бөгөөд одоогоор 2018-2019 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсгөлд үнэлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна. / “Чанарын гарын авлага” 2019 он/

### **Анхаарах асуудал:**

- Байхгүй.

### **Зөвлөмж:**

- Сургалт эрдэм шинжилгээний ажлын үнэлгээг судалгааны үндсэн дээр улам боловсронгуй болгох.
- Дотоод ажлын уялдаа холбоог сайжруулж, удирдлагын нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулах.
- Багшлах боловсон хүчнийг мэргэжил дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулж, мэдээллийн технологи ашиглах чадварыг дээшлүүлэх.

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ТЗДС-ийн оюутны журам, гэрээ, маягтууд
- Оюутны онолын мэдлэгийг үнэлэх онлайн программууд
- Оюутнуудын сургалтын явцад дүн шинжилгээ хийсэн тайлан

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчийн эцсийн үнэлгээ ил тод, , шударга байлгахын тулд багшаас оюутанд 70 хүртэл оноо өгөх ба үлдсэн 30 хүртэл оноог сургалтын албанаас хөндлөнгийн үнэлгээ хийдэг журамтай.

### **Анхаарах асуудал:**

- Оюутны хандлагыг үнэлэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох.

### **Зөвлөмж:**

- Төмөр замын мэргэжлийн онцлогтой уялдсан “Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага”-ыг үнэлэх үнэлгээний цогц шалгууртай байх, түүнийгээ тасралтгүй, тогтвортой байх ажил олгогчдын зөвлөлийг байгуулан дүрэм журмыг шинэчлэн боловсруулах.

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

##### Илрэл нотолгоо:

- ТЗДС нь өөрийн эзэмшилд **2 хичээлийн байр**, зургаан сургалтын анги танхим, **8 лаборатори**, номын сангаас гадна оюутны чөлөөт цаг өнгөрөөх биеийн **тамирын заал**, зоогийн газартай. Нотлох баримтаас үзвэл нэг оюутанд 3.7 м<sup>2</sup> хичээлийн анги танхим, лаборатори, багш нарт 5.4 м<sup>2</sup> талбай ногдож байна.
- Сургалтын анги танхимын эрүүл ахуйн шаардлагад сургалтын алба хяналт тавих ба УБТЗ-ын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанаас улирал бүр “Галын аюулаас урьдчилан сэргийлэх” **үзлэг хийж, дүгнэлт гаргадаг**.
- Монгол Улсын хэмжээнд ганц байдаг 3486 м<sup>2</sup> талбай бүхий төмөр замын **полигонд** сургалтын үйл ажиллагаа явуулдаг.

#### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

##### Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хичээлийн болон оюутны байранд mobicom, wicom компаний төслийн хүрээнд утасгүй интернет төхөөрөмж нэвтүүлсэн. Оюутнуудад тонгоруу сургалтын арга ашиглан сургалт зохион байгуулах боломж бүрдүүлсэн байна.
- Сургалтын лаборатори, кабинетийг тохижуулахад жил бүр 10- 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

##### Анхаарах асуудал:

Байхгүй.

##### Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд чөлөөт цагаар ирж суух болон бие даан суралцах боломж, лабораторийг нэмэгдүүлэх.
- Хувцасны өлгүүрт дараалал үүсдэг асуудлыг шийдэх.

#### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

##### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн онцлогоос хамаарсан сургалтын танхим, лаборатори нь зайлшгүй шаардлагатай хичээл практикийн нөөц, үзүүлэн тараах материал, хэрэглэгдэхүүн, **видео хичээлээр** хангагдсан байна.
- Зам аж ахуйн ашиглалтын үеийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан полигон нь ТЗММА мэргэжлийн ангийн оюутнуудад бодит амьдрал дээр тулгардаг асуудлыг шийдвэрлэх, аюулгүй байдлын хангаж ажиллах ур чадварыг олгох **сургалтын талбай**.
- Орчин үеийн инженерийн хэрэглээний **программ хангамжийг** мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрт тусган оруулсан байна.

#### Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

##### Онцлог зүйл/Туршлага:

- Хичээл сургалт, дадлагын үед аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар тухайн бүрд танилцуулж байгаа нь чухал ач холбогдолтой байв.
- “Техникийн зураг зүй, CAD” хичээлээр AutoCAD, CAE технологи хичээлээр Solidworks-2015, Электроникийн үндэс, хэрэглээ хичээлээр Proteus программ ашиглаж байгаа нь орчин инженерийн хэрэглээний программыг ашиглах чадварыг хөгжүүлэхэд чухал туршлага болж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлд ашиглаж байгаа зарим хэрэглээний программ хангамж нь лицензгүй байгаа нь дээд сургууль, сургалтын байгууллагын ёс зүйд нийцэхгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Цаашид хэрэглээний программ хангамжийг худалдан авах төлөвлөгөө гарган үе шаттай хэрэгжүүлэх.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ТЗДС-ийн номын сан нь нийт 40980 ширхэг номын фондтой, 140 суудалтай уншлагын танхимтай, 3 номын санчтай үйл ажиллагаа явуулж байна. Тус номын сан нь өдөрт дунджаар 150 багш, оюутанд уншлагын танхимаар үйлчилгээ үзүүлдэг. Нийт номын 60,1 хувь нь мэргэжлийн ном, сурах бичгээс бүрдэнэ.
- E-library номын сангийн цогц программ нэвтрүүлэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай материаллаг бааз, ном сурах бичгийн төсвийн төлөвлөлтийг **хөтөлбөрийн баг** гаргаж, ТЗДС-ийн захирал УБТЗ ерөнхий инженерийн зөвлөлөөр хэлэлцэж баталдаг. Сургалтын орчин, материаллаг баазыг сайжруулахаар хийгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг сургуулийн захирлын гэрээний биелэлт болон багшийн өөрийн үнэлгээний тайлангаар хянадаг.
- Шинээр худалдан авах номын захиалгыг хичээл зааж буй багшийн саналыг үндэслэн сургалтын заах **арга зүйн зөвлөлөөр** хэлэлцэж шийдвэрлэнэ.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Судалгаанд суурилан жил бүр оюутны гарын авлагыг шинэчлэн боловсруулж, тоог нэмэгдүүлэх.
- Багш нар орчин үеийн сургалтын арга технологи, сурах орчныг өөрчлөх талаар санаачилгатай оролцсон багш нарыг урамшуулдаг байх.
- Оюутан багаар болон бие дааж ажиллах орчныг бүрдүүлж өгөх талаар анхаарч ажиллах.

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулсан байна. Үүнд:
  - o Хөтөлбөрийн ажлын хэсэг байгуулах тухай /2017.03.20/
  - o Сургалтын хөтөлбөр батлах тухай захирлын тушаал /2018.10.12/ зэрэг байна.
- Богино болон урт хугацааны төлөвлөгөөнүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн төлөвлөгөөнүүдэд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулж ажилласан нь холбогдох **материалаар** нотлогдов.
- Сургалтын үйл ажиллагаандаа **Cloud Unimiss** программыг хэрэгжүүлж сургалтын удирдлага, мэдээллийн системийг үр дүнтэй ашиглаж мэдээллийн бааз бүрдүүлж түүний өгөгдлөөс дүн шинжилгээ хийж эхэлж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- 1995 оноос ашиглалтын инженерээр бэлтгэж эхэлсэн ба 20 гаруй жилийн туршлага байна. Энэ туршлагыг үр дүнд суурилсан сургалт руу шилжүүлэн хэрэгжүүлэх зохион байгуулах бүрэн боломжтой байна.

##### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөртэй холбоотой хийгдэж байгаа судалгаа шинжилгээ үр дүнг тодорхой гаргаж хөтөлбөрийн зорилго, зорилт, хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулах.
- Дунд болон урт хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийх шаардлагатай.

##### **Зөвлөмж:**

- Жил, сарын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг тайлагнах, мөн шалгуур үзүүлэлтээр нь дүгнэдэг болох.
- Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой гаргаж байгаа тушаал, заавар, хэлэлцүүлгийг баталгаажуулсан нотлох баримтыг бүрдүүлж байх.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож, багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүрээнд хамтарсан сургалт, судалгаа, олон нийтийн ажлыг дээшлүүлэх зорилтуудыг хангахын тулд дотоодын 12, гадаадын 10 байгууллагатай хамтарч ажилладаг байна. Ихэнх байгууллагатай багш оюутан солилцох, судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах гэрээгээр хамтран ажилладаг байна. Жишээ нь: УБТЗ-ын Замын албаны захиалгаар мэргэжил дээшлүүлэх сургалт, Солонгос улсын Дунян их сургууль **хамтын ажиллагааны гэрээ** гэх мэт.
- Нийгэмд хандсан ажил үйлчилгээнд тус сургууль нь жил бүр Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад, нийтийн тээврийн компаниудад “Төмөр замын гарам” нэртэй **өдөрлөг зохион байгуулж** сургууль болон төмөр замын болон замын хөдөлгөөний дүрмүүдийг сурталчилдаг байна.
- Тус сургуулийн 65 жилийн ойгоор төгсөгчдийн уулзалтуудыг зохион байгуулж, мөн төгсөгчдийн холбоог байгуулах, цаашид үйл ажиллагааг жигдрүүлэх удирдах бие **бүрэлдэхүүнүүд томилогдсон** байна.
- Төгсөгчдийн машин механизмийн чиглэлээр давтан сургалтыг жил бүр 25-30 хүний бүрэлдэхүүнтэй, 7-21 хоногоор зохион байгуулдаг байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгч нар нь мэргэшүүлэх сургалтад тогтмол хамрагддаг.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн холбоотойгоо хамтарч тодорхой үйл ажиллагаа зохион байгуулдаг болох.
- Хамтарч ажиллаж байгаа байгууллагуудтай багш оюутан солилцоо болон бусад үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам боловсруулж ажиллах.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрт ногдох сургалтын төлбөрийн орлогын **1.7 хувь нь** багш, суралцагчдын хөгжилд зарцуулагддаг.
- ТЗДС нь “УБТЗ” ХНН-ийн санхүүжилттай Монгол-Оросын хамтарсан өмчийн сургууль бөгөөд сургуулийн нийт санхүүжилтийн 75% нь сургалтын төлбөр, 8% нь өөрийн бусад орлого, 6% нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, **11% нь УБТЗ-ын татаасын эх үүсвэрээс** тус тус бүрдэж байна.
- Оюутны техник сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр “Техник загварын клуб” байгуулах, “Робокон-2019” тэмцээнд оролцуулах зэрэг зардлуудыг төлөвлөж дэмжлэг үзүүлдэг байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “УБТЗ” ХНН-ийн удирдах газрын зардлын төсөвт багш, оюутны хөгжилд зориулсан зардлууд тусгагддаг.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшил бусад байгууллагаас санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлэх.

### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- УБТЗ-ын Хүний нөөцийн алба болон бусад салбараас гаргасан хяналтын тоогоор элсүүлж сургалт зохион байгуулагддаг.
- Цаашид элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, зорилтот элсэгчдийг элсүүлэн суралцуулах чиглэлээр УБТЗ-ын замын санхүүжилтээр элсэлтийг сурталчлах, хөгжүүлэх чиглэлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эрхүүгийн Зам харилцааны их сургуультай хамтарсан “2+3” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг тогтворжуулах, хэрэгжилтийн явцыг тандах судалгаа холбогдох материалыг боловсруулах.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг тогтвортой байлгахын тодорхой үр дүн хүрэхүйц төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

#### 4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор хөтөлбөрийн талаарх **мэдээллийг элсэгчдэд, суралцагчдад, төгсөгчдөд** зориулсан гэж 3 ангилан тогтмол танилцуулж ажилладаг байна. Элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн нэгдсэн танилцуулгыг боловсруулж, УБТЗ-ын шугам зам дагуу байрлах ЕБС-ийн төгсөх ангийн сурагчидтай уулзах, мэргэжлийн танилцуулга хийх ажлыг сүүлийн 2 жилийн хугацаанд /2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд/ тогтмол хийж хэвшсэн.
- Суралцагчдад зориулсан “Бакалаврын оюутны гарын авлага” шинээр найруулан боловсруулж хэрэгжүүлж байна.
- Төгсөх оюутнуудад зориулсан “**Ажил олгогч-Төгсөгчид**”-ийн уулзалтыг жил бүрийн IV сард мэргэжил бүрийн чиглэлийн дагуу тухайн хөтөлбөрөөр төгсөөд 3-5 жил ажилласан бүрэлдэхүүнүүдийг оролцуулдаг байна.

##### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

##### Онцлог зүйл/Туршлага:

- УБТЗ-ын даргын тушаалаар мэргэжлийн чиглэлийн дагуу байгууллагууд руу хуваарилагдан ажилладаг учраас төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг тодорхой гаргадаг байна.
- Шилдэг төгсөгчдөд сонгон шалгаруулалтгүй шууд ажлын байраар хангах зорилгоор “Ажиллах эрхийн урилга”-ыг олгодог байна.

##### Анхаарах асуудал:

Байхгүй.

##### Зөвлөмж:

- Вебсайтын мэдээллийг байнга шинэчилж өөрсдийн үйл ажиллагааг нээлттэй болгох, тогтмол ажиллуулах

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

#### Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

##### Илрэл нотолгоо:

- Элсэлтийн дүрэм журмыг жил бүр сургуулийн захирал БСШУСЯ-наас гаргасан шалгуурт нийцүүлэн батлах ба УБТЗ ХНН-ийн хүний нөөцийн албатай хамтран элсэлтийг зохион байгуулдаг. Мөн элсэлтийн комисст ажиллах бүрэлдэхүүн, элсэх оюутны тоог ТЗДС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг. <http://rail-inst.mn/pg/2152> веб хуудсаар сурталчилгаа явуулдаг.
- Элсэлтийн гарын авлагыг шинэчлэн боловсруулсан 2018 он.
- Шинэ оюутны материалыг сургалтын албан мэргэжилтэн Б.Ариунболор хариуцан ажиллах ба UNIMIS e-cloud сургалтын үйл ажиллагааны программ мэдээллийн баазыг бүрдүүлдэг.
- ТЗДС-д авто инженерийн хөтөлбөрөөр шинээр элсэн орсон оюутны математик, физикийн хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) онооны судалгаа.

##### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

##### Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС-д Авто инженер хөтөлбөрөөр элсэн орж байгаа шинэ оюутнуудын математик, физикийн хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) дундаж оноо жил бүр 10 оноогоор ахин 2018-2019 оны хичээлийн жил 510, 511 оноо болсон нь бусад их сургуультай харьцуулахад өндөр дундаж оноо ба элсэлтийн үйл ажиллагааг зөв зохион байгуулж байгааг харуулж байна.
- Элсэлтийн үйл ажиллагааг УБТЗ-ийн шугам замын дагуух тулгуур өртөөдөд /Сүхбаатар, Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Чойр, Сайншанд, Баянтүмэн (Дорнод)/ зохион байгуулсан ба хамгийн их элсэлт авсан байна.

**Анхаарах асуудал:**

Байхгүй.

**Зөвлөмж:**

Байхгүй.

## 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Зөвлөх багшийн үүргийг “Оюутан суралцах гэрээ”-нд тусгасан, ажлын төлөвлөгөөг багшийн журнал дээр бичиж салбарын эрхлэгч баталгаажуулдаг. Зөвлөх багшаар ажиллах В цаг /оюутан тутамд 0,03/ гүйцэтгэл тооцно. /УБТЗ даргын 2018 оны А/525 тоот тушаал/
- Зөвлөх багш оюутантай ажилласан хавтастай байх ба хавтаст оюутны анкет, төлбөр төлсөн мэдээ, ангийн хурлын тэмдэглэл, дүрэм, журам танилцуулга хийх хууль эрх зүйн чиглэлээр зөвлөн гарын үсэг зурсан мэдээ байдаг. Зөвлөх багш улирал бүр оюутан бүртэй сурлагын амжилтын талаар дүн шинжилгээ хийж, ирээдүйн ажил мэргэжил цаашид суралцах зорилгыг тодорхойлж өгдөг.
- Эрдэмтэн нарийн бичгийн дарга Н.Бямбасүрэн Оюутны эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулснаар оюутны суралцах, судлах арга зүйг байнга хөгжүүлж байна. Эрдэмтэн нарийн бичгийн даргын жилийн ажлын төлөвлөгөөнд Оюутны эрдэм шинжилгээний хурлыг хоёр удаа зохион байгуулахаар төлөвлөсөн байдаг. Жил бүр зохион байгуулсан оюутны эрдэм шинжилгээний хурал нь хурлын хөтөлбөр, оюутны хэвлүүлсэн бүтээлээр батлагдаж байна.
- Цэрэгжилт, спорт дугуйлан хариуцсан багш дасгалжуулагч / С.Ерөөлт/ ажлыг байрны тодорхойлолтод секц, дугуйлан хичээллүүлэх, сургуулийн хэв журам, сахилга бат хариуцан дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн хэв журам, сахилга батыг чанд сахиж, төмөр замын дүрэмт хувцас өмсөж байгаа нь оюутны ёс зүй, хувь хүний төлөвшилтөд эергээр нөлөөлдөг харагдаж байна.

**Зөвлөмж:**

- Оюутны үйлчилгээний талаар санал асуулга, сэтгэл ханамжийн судалгаа явуулж, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

## 5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Спортын дугуйлан, урлаг, хувь хүний хөгжлийн талаар олон нийтийг хамарсан оюутны үйл ажиллагаа тогтмол зохион байгуулж ирсэн байна. Оюутны хөгжлийг дэмжих, ажлыг эрчимжүүлэх хүрээнд ТЗДС-ийн 2018 онд гаргасан зардлыг 2016 оны зардалтай харьцуулахад 2,5 дахин их буюу 87,2 сая төгрөгт хүрсэн байна.
- Техникийн загварын клубийн дотоод журам, дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд хийгдсэн “Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ”, Ган зам мэтгэлцээний

- клубийн ажлын тайлан, мэтгэлцээний клубийн ажиллаж байгаа зураг, ТЗДС-ийн оюутны хөгжилд зориулсан хичээлээс гадуурх секц, дугуйлангийн мэдээлэл.
- ТЗДС-ын захирлын 2018 оны “Шилдэг оюутан урамшуулан шагнах тухай” А/229 тоот тушаал.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд оюутнууд чөлөөт цагаа өнгөрүүлэх клуб бий болсон. ТЗДС-аас захирлын тушаалаар зөвшөөрөгдсөн 5 клуб тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Клуб бүр өөрсдийн алсын хараа, зорилго зорилтоо дэвшүүлэн, дүрэм журмын дагуу удирдагч багшийн заавраар ажилладаг.
- Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Робокон, Монгол инженер, Металл судлалын олимпиад, Инженерийн зургийн автоматжуулалт зэрэг тэмцээн, уралдаанд үр дүнтэй оролцсон оюутанд кредитийн хөнгөлөлтийг ТЗДС захирлын тушаалаар олгодог.
- УБТЗ-ын даргын тушаалаар “Оюутны отряд”-аар зам ангид цалинтай ажиллах боломжоор хангадаг.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Оюутны 2018 оны гарын авлагын “ТЗДС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7–р бүлэгт сургалтаас чөлөө олгох, шилжилт хөдөлгөөн хийх талаар, 8-р бүлэгт кредит дүйцүүлэн тооцох, 10 бүлэгт оюутныг урамшуулах тухай заасан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Шилжилт хөдөлгөөн, багц цагийн дүйцүүлэлтийг бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмаар зохицуулагдана.

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Захирлын 2018 оны 10 сарын 26 ны өдрийн А/190 тоот тушаалын 1-р хавсралт. Төмөр замын дээд сургуулийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам.
- Авто инженер /D071601/ хөтөлбөрөөр суралцан /2018 он/ Төмөр замын машин механизмын ашиглалт мэргэжлээр бакалаврын зэрэг олгосон Цэгмэдийн Гансүхийн дипломын хуулбар.
- Төмөр замын машин механизмын ашиглалт мэргэжлээр төгссөн Цэгмэдийн Гансүхийн ТЗДС захирал Ж.Пүрэвсүрэн, дэд захирал Б.Сэлэнгэ нар баталгаажуулсан, нийт 132 багц цагийн багтаамжтай, хувь хүний гүйцэтгэл, агуулгын харуулсан хавсралт.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдөдөө зориулсан сургалт зохион байгуулж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сертификат олгодог.
- ТЗДС-ийн оюутан элсүүлэх, төгсгөх журмын “Төмөр замын дээд сургуулийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар төгсөгчдийн бичиг баримтыг олгоно.
- Сургуулийн зүгээс бодлогоор оюутнуудыг дэмжиж төсөл судалгаанд бүрэн хамруулж төгсгөдөг.



## Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- 2018 оны 12 сарын 25-ны өдрийн А/240 тоот “Журам батлах тухай тушаал”-ын ТЗДС-ийн хөтөлбөрийн чанарын үнэлгээний журмаар багшийн үйл ажиллагааг мэдлэг оюуны чадамж, хувь хүний чадамж, судалгааны чадамж, сургахуйн чадамж бүхий дөрвөн үзүүлэлтээр авч үзвэл:
  - Мэргэжлийн салбар, тэнхимийн удирдлагаас багшийг
  - Хөтөлбөрт оролцогч багш багшаа
  - Хөтөлбөрөөр суралцагч оюутан багшаа, төгсөгч нь багшаа тус тус үнэлж, дүнг нэгтгэж, багшийг үнэлэх журамтай байна.
- 2017-2018 оны хичээлийн жилээс доктор багшийн тоог нэмэгдүүлэх зорилгоор докторын тэтгэлэг олгож байгаа нь ирэх хичээлийн жилүүдэд доктор зэрэгтэй багшийн тоо өсөх эерэг, хандлага өөрчлөлт байна.
- Багшийн цалингийн шатлал 2010 оныхтой харьцуулахад 2 дахин өссөн байна. Энэ нь багшлах боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.
- Сургууль багш өөрийгөө хөгжүүлэх боломжийг хангасан Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шатандаа явж байгаа боловч батлагдаагүй байна.
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллаж байна.

#### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

#### Онцлог зүйл/Туршлага:

- 2013 оноос хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг нэвтрүүлсэн.
- Эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо нэмэгдсэн.
- Багшлах боловсон хүчний тогтвор суурьшил сайн.
- УБТЗ-аас багш ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч, цалин хөлсийг тодорхой үе шаттайгаар жил бүр нэмэгдүүлдэг.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг олон улсын туршлага дээр үндэслэн 2018 онд боловсруулан хэрэгжүүлж эхэлж байна
- Багшийн хөгжлийн эрх зүйн орчныг бүрдүүлэн ажилласан.
- Баг бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажилладаг.
- Эрдэм шинжилгээ, олон нийтийн ажилд үнэлгээ дүгнэлт өгөх эрх зүйн орчин бүрдсэн.
- 2018 онд Төмөр замын дээд сургуулийн “Багшийн хөгжил” хөтөлбөрийг боловсруулж, чадамжийн үнэлгээг багшийн хөгжлийн загвар, чадамжийн хүрээний жишиг асуулгаар асууж, хөтөлбөрт хичээл заадаг багш бүрээр өөрийн үнэлгээ хийлгэж, 2019 оны 01 сард үнэлж, дүгнэсэн.
- Цаашид хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг Багшийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан илүү боловсронгуй болгоно.

#### Анхаарах асуудал:

Байхгүй.

#### Зөвлөмж:

- CDIО буюу үр дүнд суурилсан сургалтын арга зүйн стандартын хэрэгжилтийг сайжруулахад профессорын багийг чадавхжуулах.

- ЗТХЯ, БСШУСЯ, ХНХЯ, УБТЗ ХНН дөрвөн удирдлагын даалгаврыг биелүүлдэг учир бичиг цаасны ажил ихтэй байдгийг багасгах.
- Төгсөгчийн загварыг сайжруулан боловсруулж, стандартын 2-р түвшний ур чадваруудын жагсаалтыг үндэслэн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг хэрхэн үнэлэхийг хичээл бүрээр тодорхой болгох.
- Хөтөлбөрийн үнэлгээний шалгуурыг тодорхой болгох.

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ” гэж онцлон заасан байдаг бөгөөд уг бодлогын баримт бичгийн 5.3-т “Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заажээ. Түүнчлэн “Тогтвортой хөгжил-Дээд боловсрол” улсын II зөвлөгөөнд **“Их сургуулийн хөгжлийн тулгуур нь багшийн хөгжил мөн”** гэж тодорхойлсон бөгөөд орчин үеийн их сургуулийн багш нь “судалгаа хийж, сургалтын үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ манлайлагч байх” ёстой гэж багшийн ажлын үнэлэмжийг олон улсын түвшинд онцлон тодорхойлсны дагуу хэрэгжүүлэх ажлын тушаал, шийдвэр, төлөвлөгөө, удирдамжуудыг хэрэгжүүлдэг байна.
- Өнөөдөр төмөр замын үндсэн 7 мэргэжлээр бакалавр, техникчийн сургалтыг нийт 1500 гаруй оюутантай, 117 багш, ажиллагчидтай байгаа бөгөөд үүнээс төмөр замын мэргэжлийн багш 30, суурь боловсролын багш 20, хэл соёлын багш 6, нийт 57 багшийн бүрэлдэхүүнтэйгээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш бүр “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-тэй, түүнийгээ нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлдэг туршлага багш бүрд байгаа сайн тал ажиглагдлаа.
- Багш нарын боловсролын зэрэг зарим талаар өссөн, үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2010-2011 оны хичээлийн жилд Sc.D 1, Ph.D 3 байсан бол, 2018-2019 оны хичээлийн жилд Sc.D 1, Ph.D 9 болсон байна.
- Төмөр замын мэргэжилтэй боловсон хүчний мэргэжлийн нэг онцлог нь тухайн багш, засварчнаас эхлээд, инженер багш болтлоо бүхий л нарийн мэргэжлийн үе шатанд ажиллаж, чадвартай, зөв хандлагатай байх зарчмыг баримталж, хөгждөг өндөр ур чадвартай, багшлахуйн арга технологийг нэвтрүүлж байгаа тэргүүн туршлага бодит байдлаар хэрэгжиж байна.
- Мөн мэргэшсэн, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоо сайтай, зөвлөн туслах, дагалдан суралцах, дадлагажих, туршлагажих, өөрсдийнхөө туршлагыг сайжруулах явцдаа багш хөгжиж байдаг, сурган хүмүүжүүлэх арга барилын онцлогтойн дээр багш нарын заах арга ур чадварын өсөлт хөгжилтийг илтгэн харуулах тодорхой баримт бичигтэй.
- Багшлах боловсон хүчний сонгон шалгаруулалтын журам шинээр боловсруулж, судалгаан дээр үндэслэн, шинээр ажилд орж байгаа багшлах боловсон хүчнийг сонгон шалгаруулалтаар 2013 оноос авч хэрэгжүүлж ирснийг тэмдэглэн хэлье.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Багшийн сургалт, эрдэм шинжилгээний хөгжлийг дэмжсэн арга зүйн удирдамж, зөвлөмжөөр хангах, энэ талаар хийсэн бодит ажлын биелэлтийг /тодорхой бүтээл, арга, арга зүйн материалуудыг боловсруулж хийсэн талаар жагсаалт, бүтээл гаргах.

- Багшийн хөгжлийг дэмжсэн чиглэлээр оногдох орлого, зарлагыг тусад нь тооцож, дэлгэрэнгүй гаргах, тухайлбал, багш нарын хамтын бүтээл, сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийг хэвлүүлэхэд зориулсан гэх мэт.
- Багш нарын хамтын бүтээл, сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийг хамтран боловсруулж, бүтээл гаргах тал дээр төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай байна.
- Багш нарын сургалт, эрдэм шинжилгээний ажлын зохиогчийн эрхтэй бүтээл, үр дүн, өгөөжийг олон нийтэд хүлээн зөвшөөрснийг нотлон харуулах баримт бичгүүдийн жагсаалт /бүтээлийн үзэсгэлэн/ гаргаж ажиллах.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэлийг тооцдог дүрэм журам хэрэгждэг.
- Багшийн хөгжлийг дэмжих, ажлыг үнэлэх, урамшуулах тухай журам, заавруудыг шинэчлэн хэрэгжүүлдэг

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн ажлыг үр дүнг дэмжиж, 13 дахь сарын цалингаар тогтмол урамшуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Судалгаанд суурилсан “Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ” ажлын нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх талаар удирдлагын зүгээс анхаарлаа хандуулан ажиллах
- Багш нараа эрдэмжүүлэхэд бодлогоор дэмжих.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих арга зүйгээр хангах, санхүү төсвийг нэмэгдүүлэх.
- Мэргэжлийн онцлогтой үндэсний хэмжээний хамтын суурь болон инновацийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн онцлогтой нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр ажлын тушаал, шийдвэрүүд хэрэгждэг.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Зарим мэргэжлийн багш нарын /багийн ажлын/ сургалт заах арга зүйн шинэ санаа, шинэлэг ажлын туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

#### **Анхаарах асуудал:**

Байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Багш нар, мэргэжилтнүүдэд зориулсан төрөлжсөн болон захиалгат сургалтын хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжид хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байх, зөвлөмжийн дагуу хэрхэн ажилласан ажлын тайлан мэдээлэл нээлттэй байх

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2016.08.29 өдрөөс эхлэн тус сургуульд дотоод чанарын баталгаажуулалтын үндсэн **орон тооны ажилтантай** болсон ба БСШУС-ын сайдын 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх тухай” А/533 тоот тушаал, БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага, “Төмөр замын дээд сургуулийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний биелэлтийг хангах зорилгоор ТЗДС-ийн захирлын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-191 тоот тушаалаар **“Сургалтын чанарын дотоод баталгаажилтын баг”**-ийг сургалтын дотоод хяналтын мэргэжилтнээр ахлуулан, мэргэжлийн хөтөлбөрийн баг болон суурь боловсролын тэнхим, гадаад хэлний тэнхим тус бүрээс нэг ахлах багш, сургалтын арга зүйчийг оролцуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.
- Мөн дээрх ажлын баг нь төлөвлөгөө болон ажиллах журмаа боловсруулан “Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага” гарган ажиллаж эхэлсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- ТЗДС-ийн захирлын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-191 тоот тушаалаар “Сургалтын чанарын дотоод баталгаажилтын баг” ажилладаг.
- ХНН УБТЗ-д Дотоод хяналт шалгалтын алба гэж тусдаа алба байх бөгөөд энэ алба нь аж ахуй нэгжийн үйл ажиллагааг бүх үзүүлэлтээр жилд 2-оос доошгүй удаа тогтмол ба тогтмол бус хугацаанд хянаж шалгадаг.

##### **Анхаарах асуудал:**

- Сургалтын чанарын дотоод баталгаажилтын багийн бие бүрэлдэхүүнийг тухайн чиглэлээр сургах, туршлага судлуулах, хийгдэх ажлуудыг тодорхой болгох

##### **Зөвлөмж:**

- Чанарын дотоод баталгаажуулалтыг хийхийн тулд хөтөлбөрт оролцогч талуудаар / Ажил олгогч, суралцагчийн эрэлт хэрэгцээ гэх мэт/ хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхой шалгуураар үнэлүүлэх, дүн шинжилгээ хийх, тайланг бичиж, цаашид хөтөлбөрийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх.

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхийн тулд зорилтуудыг дэвшүүлэн хөтөлбөрөөр суралцагчийн хүрэх дүнг тодорхойлох зорилгоор оюутнуудаас хөтөлбөрт хийсэн үнэлгээ, оюутнууд хөтөлбөрийн багш нарыг үнэлсэн үнэлгээ, төгсөгчидийн ажил эрхлэлтийн судалгаа, төгсөгчидийн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшил зэргийг, ажил олгогч буюу УБТЗ-ын замын албатай хамтран сэтгэл ханамжийн судалгааг гаргаж түүнд дүн шинжилгээг хийж цаашид анхаарч ажиллах асуудлуудыг тодруулж байна.
- УБТЗ-ын ажил олгогч буюу Замын алба тухайн хөтөлбөрөөр төгсөгчидийн боловсролын түвшинг **“Сайн”** гэж дүгнэсэн ба тухайн хөтөлбөрийн агуулга УБТЗ-ын ажил олгогч буюу Замын албаны шаардлагад **“Бүрэн нийцдэг”** гэсэн дүгнэлт хийсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2015-2016 оны хичээлийн жилээс 2017-2018 оны хичээлийн хооронд суралцагчдийн сурлагын голч дүнгийн судалгааг гаргаж, түүнд анализ хийснээр цаашид сургах суралцах үйл ажиллагааг сайжруулж төгсөгчдийн хүрэн түвшинг тодорхойлохоор ажилласан байна.
- 2018 онд тус сургуулийн 65 жилийн ойн ажиллагаа явагдсан тулд төгсөгчдийн судалгааг тодорхой гаргасан нь цаашид хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах боломжтой байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох зорилгоор ажил олгогчдийн сэтгэл ханамжийн судалгаа болон төгсөх ангийн оюутнуудын хөтөлбөрт өгсөн үнэлгээ, суралцагчдаар багшийг үнэлүүлсэн судалгааг хийсэн боловч судалгааг олон талаас анализ хийж цаашид хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулахад ашиглаагүй байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн үр дүнг оролцогч талууд баталгаажуулах шаардлагатай.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төмөр замын дээд сургууль нь Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн “Дээд боловсролын байгууллагын” магадланд итгэмжлэлд 2001, 2006, 2018 онуудад амжилттай магадлан итгэмжлэгдсэн. /Гэрчилгээний хуулбаруудыг хавсаргалтаар үзүүлсэн болно. /
- “Авто инженер” мэргэжлээр 1995 оноос бакалаврын зэрэгтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсэн ба сүүлийн жилүүдэд инженерийн зохион бүтээх үйл ажиллагааг хөгжүүлэх, хийж бүтээх чадамжийг дээшлүүлэх улсын болон олон улсын олимпиад, тэмцээнүүдэд оюутнууд оролцож 2009 оны төгсөгч Л.Бямбасүрэн, П.Баттөгс, Н.Бат-Эрдэнэ нар “Материал эсэргүүцэл” хичээлийн Улсын олимпиадад тэргүүн байр, 2012 оны төгсөгч Б.Бат-Энх “Материал эсэргүүцэл” хичээлийн Улсын олимпиадад хүрэл медаль, 2019 онд 4 оюутан ROBOCON-2019-д амжилттай оролцож байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- УБТЗ-ын ажил олгогчоос шилдэг төгсөгчдөд сонгон шалгаруулалтгүй шууд ажлын байраар хангах зорилгоор “Ажиллах эрхийн урилга”-ыг олгодог байна.

##### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлүүлэхээр холбогдох мэргэжлийн холбоодыг хамруулах, судалгаа шинжилгээг тодорхой болгох, хамтарч ажиллах хүрээг гаргах

##### **Зөвлөмж:**

- Эрхүүгийн зам харилцааны их сургуультай хамтарсан “2+3” хөтөлбөр хэрэгжүүлснээр цаашид ОХУ-д хүлээн зөвшөөрөгдөх мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх ажлыг эрчимжүүлэх.

### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

## ДҮГНЭЛТ

Монгол Улсад төмөр замын тээвэр эрчимтэй өргөжин хөгжиж шинэ төмөр замын бүтээн байгуулалтууд эхлэх гэж байгаа нь төмөр замууд нь орчин үеийн шаардлагад нийцсэн өөрөөр хэлбэл бүрэн автомат хориглолтой, уулзваргүй зам төмөртэй, хүнд даацын зам байна. Ийм төмөр замыг шинээр барьж байгуулахад тусгай мэргэжлийн иж бүрэн механикжуулагдсан замын анги болон орчин үеийн төмөр замын машин механизмын ашиглалт мэргэжлийн боловсон хүчинг Авто инженерийн хөтөлбөрөөр хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлсон байна.

Төмөр замын салбарын хөгжлийн ирээдүйн төлөвтэй уялдуулан Авто инженерийн хөтөлбөрөөр мэргэжлийн ажлын байранд тавигдах ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангаж, тасралтгүй хөгжих боломжтой нь өөрийг үнэлгээний тайлангаас харагдаж байна.

Мөн инженерийн боловсрол олгодог дэлхийн их, дээд сургуулиудын сургалтын тэргүүний арга зүйг судлаж, өөрийн онцлог нөхцөлд тохируулан нутагшуулахын тулд сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших CDIO-н ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц, хичээл хоорондын уялдаа холбооны зураглалыг боловсруулан ажиллаж байгаа нь давуу тал болсон байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			Хөтөлбөрийн зорилго, зорилтын ажил олгогчдоор хэлэлцүүлсэн боловч суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг тасралтгүй үнэлэх нэгдсэн бодлогын бичиг баримт байсангүй.
2	Сургалтын үйл ажиллагаа	2			Үр дүнд суурилсан сургалтыг зохион байгуулж, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирч байгаа нь нотлогдсон.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			Хөтөлбөрийг үр дүнг хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, сургалтын орчин бүрдсэн байна.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			Хөтөлбөрийн баг сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй сайжруулах менежментийг хийдэг.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			Суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцах боломж бүрдсэн байна.
6	Багшийн үйл ажиллагаа	2			Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжих боломжийг олгож байна
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт		1		Дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай болох эхлэл тавигдсан байна.
<b>Дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД сургуулийн “АВТО ИНЖЕНЕР” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Ө.Ганбат

Шинжээчийн багийн гишүүн: Э.Нацагдорж

Шинжээчийн багийн гишүүн: Б.Оюунцэцэг

## ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн, оролцогч талуудын үүрэг, хариуцлага, тэдгээрийн хэлэлцэх асуудлыг тодорхойлж, баталгаажуулах нэгдсэн бодлогын бичиг баримттай байх.
2. Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх, дотоод чанарын баталгаажуулалт хийхдээ сургалтын үйл явцад нь тасралтгүй зөвлөн тусалж, хянаж, эцсийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлттэй болох.
3. Хөтөлбөрийн зорилго, зорилт нь төгсөгч оюутны мэдлэг, чадвар, хандлага таван жилийн дараа хүрэх чанарын ахиц дэвшлээр тодорхойлох шаардлагатай.
4. Хөтөлбөрийг тасралтгүй, тогтвортой хөгжүүлэхэд ажил олгогчдын зөвлөл /АОЗ/-ийг идэвх, санаачилгатай ажиллуулах хэрэгцээтэй байна. Учир нь АОЗ-д төгсөгч, суралцагчид, багш нарын төлөөлөл оролцдог.
5. Сургалтын төлөвлөгөөнд байгаа мэргэжлийн онцлогтой зарим хичээлд хэрэглээний программ хангамжийг ашиглахдаа оюуны өмчийн зохих зөвшөөрлийг авч хэрэгжүүлэх.

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Танхилсайхан	багш	доктор		Физик
2	М.Бямбасүрэн	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	доктор		

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	А.Анхбаяр	СПМ-3	Дунджаас доогуур сургалтан
2	Х.Баасансүрэн	СПМ-4	Сайн сурдаг
3	О.Өсөхбаяр	СПМ-3	Байранд

##### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Лхагвасүрэн	УБТЗ замын аж ахуйн алба	Ерөнхий механик
2	Д.Батбаатар	Зам засварын машинт станц	Дарга
3	Б.Буяндэлгэр	Зам засварын машинт станц	Хүний нөөц
4	Д.Баярмаа	УБТЗ замын аж ахуйн алба	Механик инженер

##### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	М.Үүрцайх	2007	УБТЗ	ВПО-3000 дизельчин
2	Г.Энхжаргал	2007	УБТЗ	Ук машинч
3	А.Арган	2012	УБТЗ	КМД кранч, машинч
4	Д.Бат-Оргил	2012	УБТЗ	ВПО-3000 цахилгаанчин
5	Б.Бат-Энх	2012	УБТЗ	ВПО-3000 машинч
6	Ж.Баттулга	2003	УБТЗ	УК краны операторч



## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

  
**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ  
ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ**  
 210335 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
 Энхтайвны ертөнц чөлөө 44, Утас: 24-22-60, Факс: 24-22-70  
 E-mail: tai-ins@ubtz.mn

2019.06.10 № 4/382  
 тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

2019 оны 05 дугаар сарын 9,10-ны өдрүүдэд БМИУЗ-ийн шинжээчийн баг /ахлагч Ө.Ганбат, гишүүд Б.Оюунцэцэг, Э.Нацагдорж/ нар ТЗДС-ийн "Авто инженер" хөтөлбөрийн "Төмөр замын машин механизмын ашиглалт" мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж, бодит байдал дээрх сургалтын үйл ажиллагаатай танилцаж ажилласан.

2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн "Шинжээчийн тайлан"-г хүлээн авч, уншиж танилцлаа. Шинжээчийн багийн гаргасан дүгнэлт, тайланд тусгагдсан анхаарах зүйлс, зөвлөмжүүдийг хүлээн авч байна. Цаашид тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу сайжруулах чиглэлийн ажлыг тогтмол хугацаанд, шат дараалалтай хийж гүйцэтгэх болно.

Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэх ажилд хамтран ажиллаж, үнэтэй зөвлөгөө өгч, сургалтын үйл ажиллагааг сайжруулахад сэтгэл гарган ажилласан та бүхэнд талархсанаа илэрхийлье.

  
 ЗАХИРАГД  Ж.ПҮРЭВСҮРЭН

162190277

## VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
 [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
 [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**